# Зургаан мөнгөн мичид





# Зургаан мөнгөн мичид

Улаанбаатар хот
2007 он

# ЗУРГААН МӨНГӨН МИЧИД

| | |
|---|---|
| Боловсруулсан: | Ж.Дашдондог |
| Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: | Т.Дэлгэрмаа |
| Чимэг зургийг зурсан: | Б.Болормаа |
| Монгол бичигт хөрвүүлсэн: | Х.Оюунчулуун |

INTERPRESS

Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он



Эрт урьд цагт зургаан өнчин хүүхэд товцог толгой дээр наадан суудаг юм санжээ. Тэгсэн чинь ах нь нэг өдөр хэлж:

- Зүг зүгт явж эрдэм ном сурч ирцгээе!

За тэгээд товцог толгой дээр нэг нэг мод босгоод тарж явцгаажээ.

Отгон дүү нь өмнө зүгт гүйж явсаар нэг алтан байшингийн гадна Алтан дагина байхыг үзээд, гадаа нь очиж харж суусаар байгаад тэдний гадаа унтаад өгчээ. Тэр хүү Алтан дагиныг гаравч цуг, оровч цуг байх болж.





Дагина хэлж гэнэ.

- Миний аав тэнгэрээс ирж, урд алтан худагт морио услана. Чи очиж мөргөөд ир! гээд явуулж. Хүү удалгүй гүйгээд ирж.

- За яав?

- Чамайг хармаар санагдаад хүрээд ирлээ гэж.

- За чи намайг хармаар санагдаад байвал энэ зургийг хараарай. Харин үүнийг хаяж гээж болдоггүй юм шүү! гэж захиад явуулав. Тэгтэл хүү асар удалгүй орилж бархирсаар ирэв.

- Юу болов? гэсэнд

- Зургаа хуй салхинд хийсгээд алдчихлаа гэжээ.

Тэгсэн тэр зураг хийсч явсаар Мангасын хааны нутагт очиж гэнэ.

Мангасын хаан энэ сайхан хүүхнийг эхнэр болгоно гэж эрж сурсаар хүрч ирэн, хүүг алаад Алтан дагиныг аваад явчихжээ.

Ах дүү таван хүү товцог толгой дээрээ болзсон цагтаа цугларч иржээ. Тэгтэл отгон дүүгийнх нь мод унаж хөсөрсөн байв гэнэ. Ах дүү тав юу сурснаа хэлэлцэж ярилцжээ.

Тэгсэн чинь нэг нь үхсэнийг амь оруулдаг, нэг нь хэлгүй юманд хэл оруулдаг, дуугүй юманд дуу оруулдаг, бас нэг нь далдын юмыг харж мэддэг, нөгөө хоёр нь уран сайхан сийлбэр сийлдэг, таван өнгийн будгаар ялгаж зурдаг эрдэм сурсан гэж байна гэнэ. За тэгээд далдын юм хардаг ах нь харсан чинь дүү нь үхэж үрэгдсэн байна гэнэ.

Тэгээд тавуул дүү дээрээ очоод үхсэнийг амь оруулдаг ах нь дүүгээ босгож аваад ямар эрдэм ном сурсан, яасан ийснийг нь асуувал:

- Надад сурсан эрдэм ном үгүй, нэг сайхан Алтан дагинын дэргэд байсан, зургийг нь салхинд хийсгэж алдаад,















Мангасын хаан зургийг нь олж авч, намайг алаад алтан дагиныг аваад явсан гэжээ.

Уран сийлбэрч ах нь модон шувуу хийж, будагч ах нь таван өнгөөр ялган будаж, хэлгүй юманд хэл оруулдаг ах нь гургалдайн сайхан дуу оруулж, ах дүү зургуулаа модон шувуундаа суугаад Мангасын хааныд хүрч очив.

Алтан дагина энэ сайхан шувуугаар наадах юмсан, үүнийг барьж өгдөг болоосой гэсэнд Мангасын хааныхан барих гэж оролдоод ядав. Алтан дагиныг ойртмогц үргэж цочих нь гайгүй болохоор Мангасын хаан:

- Чамд баригдаж магадгүй юм байна. Чи очоод бариад ав! гэж гэнэ. Тэгээд Алтан дагиныг ойртоод ирэхээр ах дүү зургаа шувуундаа суулгаж аваад нисээд явчихжээ.





Тэгээд тэр ах дүү зургаагийн дүү нь анх учирснаараа би сууна гэж амь оруулж авснаараа би сууна гэж ах нь хэлж, уран дуутай шувуу хийснээрээ би авна гэж сийлбэрч ах нь хэлж дагинаа булаалцах юм болжээ.

-Ачтай тустай та нарын алинтай нь сууна, алинтай нь суухгүй гэх вэ? Санасан цагтаа сард нэг удаа бие биенээ харж явъя гээд сар болоод тэнгэрт гараад явчихаж гэнэ.



Ах дүү зургаа бас тэнгэрт гарч зургаан мичид гэдэг мөнгөн одод болж гэнэ. Тэр цагаас хойш сар, мичид хоёр сард нэг удаа тохиодог болсон юм санжээ.

ᠠᠬ᠎ᠠ ᠳᠡᠭᠦᠦ ᠵᠢᠷᠭᠤᠭ᠎ᠠ ᠪᠠᠰᠠ ᠲᠩᠭᠠᠷᠢ ᠳᠤ ᠭᠠᠷᠴᠤ ᠵᠢᠷᠭᠤᠭᠠᠨ ᠮᠡᠴᠢᠳ ᠭᠡᠳᠡᠭ ᠮᠥᠩᠭᠦᠨ ᠣᠳᠤᠳ ᠪᠣᠯᠵᠤ ᠭᠡᠨ᠎ᠡ ᠄ ᠲᠡᠷᠡ ᠴᠠᠭ ᠠᠴᠠ ᠬᠣᠶᠢᠰᠢ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠂ ᠮᠡᠴᠢᠳ ᠬᠣᠶᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠳᠤ ᠨᠢᠭᠡ ᠤᠳᠠᠭ᠎ᠠ ᠲᠣᠬᠢᠶᠠᠯᠳᠤᠳᠠᠭ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠠᠵᠢᠭᠤ ᠄

# ЧИХЭР ХҮЛХВЭЛ АРААНД УУСНА
# НОМ УНШВАЛ ТОЛГОЙД ҮЛДЭНЭ

*Хүүхдийн шилдэг үлгэрийн номын эхний хуудсан дээр золгож буй гүн хүндлэлт эцэг эхчүүд ээ!*

*Хэрэв та үр хүүхдэдээ сайн ном авч өгвөл тэднийг хүмүүжүүлэх их ажлынхаа дийлэнх хувийг хийлээ гэж найдаж болно. Үлгэрийн баатрууд тэдэнд туслаж мэргэн оюун, уран сэтгэмж, сайхан сэтгэлийг бэлэглэнэ.*

*Таны хүүхдүүд энэ номоор дамжин үсэг нүдэлж үг холбосоор үлгэрийн гайхамшигт ертөнц рүү орж байна. Чихэрт дургүй хүүхэд гэж байдаггүй. Чихэр гагцхүү амтлах эрхтэнд нөлөөлдөг бол ном таван мэдрэхүйг эзэмдэнэ. Тиймээс номын амт нь чихрийнхээс хавьгүй илүү болохыг хүүхдүүд аяндаа мэдэрнэ. Энэхүү номын зургийг уран сайхны өндөр түвшинд урласан миний шавь Б.Болормаа 2005 онд Олон улсын НОМА уралдааны Гран при шагнал хүртэж Монголын хүүхдийн номын зураачдын нэрийг дэлхийн сонорт хүргэсэн билээ. Ийнхүү шилдэг үлгэр, сайхан зураг найрсан нийлсэн номын амтат чихрийг үр хүүхдийн тань гарт атгуулъя. Таалан соёрхоно уу?*

*Олон улсын хүүхдийн утга зохиолын дөрвөн удаагийн шагналт, зохиолч Жамбын Дашдондог*

Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.

